



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/553

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 3.5.3, аймгийн “2019 оны төсөв батлах тухай” 2018 оны 09/10 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын эмэгтэйчүүдийн холбооны Өвөрхангай аймаг дахь салбараас “Илүү сайхан ирээдүйн төлөө” олон улсын эмэгтэйчүүдийн түншлэлийн анхдугаар чуулга уулзалтад оролцох оролцогчдын зардалд 2000000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2000000 (хоёр сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101006